



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ноён сумын 16 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2025/008/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.Umnugovi@audit.mn

Өмнөговь аймаг

2025 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn
Аудитор: Ө.Болортуяа
Утас: 70533552 Цахим хаяг: Bolortuyau@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.02.25 № 05
танай _____ -ны № _____ -т

НОЁН СУМЫН 16 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
А.МӨНГӨНТУЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ноён сумын 16 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар анхан шатны баримтгүй зарцуулсан 370.0 мянган төгрөг, хяналт шалгалтаар дутагдсан 7,997.9 мянган төгрөгийн хохирлыг барагдуулаагүй зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.4.1, 12 дугаар зүйлийн 12.4, 13 дугаар зүйлийн 13.1 дахь хэсэгтэй нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, "Тира энерги" ХХК-тай хамтраад 2024 оны 06 дугаар сараас эхлэн сумын цэцэрлэгт суралцаж байгаа хүүхдүүдэд хадгаламж нээж сар бүр 50.0 мянган төгрөг олгож эхэлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж,

F:\2.Бичиг хэрэгл\2025он\СТА-н дүгнэлт\Төсөлг.Бичг

4625020221

аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн хөгжлийн сангаас 8,045.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 15,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 96 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБЯАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>131,608,500.10</u>	<u>164,357,497.78</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	80,041,563.63	111,249,028.61
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	80,041,563.63	111,249,028.61
3121	Төгрөг	80,041,563.63	111,249,028.61
31211	Төрийн сангийн харилцах	80,041,563.63	111,249,028.61
35	БАРАА МАТЕРИАЛ	51,566,936.47	53,108,469.17
351	Түүхий эд материал	6,697,248.47	8,615,748.47
35110	Тусгай зориулалттай материал	6,697,248.47	8,615,748.47
354	Хангамжийн материал	44,869,688.00	44,492,720.70
35410	Бичиг хэргийн материал	1,008,200.00	1,008,200.00
35420	Аж ахуйн материал	9,259,450.00	9,259,450.00
35450	Барилгын засварын материал	5,715,600.00	5,865,600.00
35460	Хүнсний материал	10,471,390.00	9,919,422.70
35470	Бусад хангамжийн материал	18,415,048.00	18,440,048.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>487,047,415.22</u>	<u>478,168,674.07</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	487,047,415.22	478,168,674.07
392	Биет хөрөнгө	483,707,415.22	474,828,674.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	379,214,903.00	394,214,903.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-28,967,805.35	-35,288,053.79
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	56,597,450.00	65,412,570.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-19,311,116.80	-29,611,550.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,282,471.56	25,282,471.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,180,143.37	-17,184,442.01
39214	Бусад үндсэн хөрөнгө	113,759,300.00	113,759,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-33,670,933.82	-46,739,814.36
39217	Ном	4,983,290.00	4,983,290.00
393	Биет бус хөрөнгө	3,340,000.00	3,340,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3,340,000.00	3,340,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>618,655,915.32</u>	<u>642,526,171.85</u>
413	Өглөг	56,500.00	00.00
4136	Бусад өглөг	56,500.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	56,500.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>618,599,415.32</u>	<u>642,526,171.85</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	618,599,415.32	642,526,171.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	370,271,284.46	370,271,284.46
51101	Өмч: - төрийн	3,340,000.00	3,340,000.00
51102	- хувийн	366,931,284.46	366,931,284.46
512	Хуримтлагдсан үр дүн	148,735,650.83	172,662,407.36
51210	Өмнөх үеийн үр дүн	148,735,650.83	148,735,650.83
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	23,926,756.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	99,592,480.03	99,592,480.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>618,655,915.32</u>	<u>642,526,171.85</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	464,596,516.00	509,122,862.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	114,774,354.00	112,336,062.00
120	Нийтлэг татварын бус орлого	114,774,354.00	112,336,062.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	36,430,354.00	88,520,942.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	36,430,354.00	88,520,942.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	349,822,162.00	396,786,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	320,647,862.00	362,118,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	320,647,862.00	362,118,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,174,300.00	34,668,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,174,300.00	34,668,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	337,846,604.08	485,196,105.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	337,846,604.08	485,196,105.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	288,776,210.20	469,265,809.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,125,593.19	307,257,833.52
210101	Үндсэн цалин	131,638,535.00	202,419,185.59
210102	Нэмэгдэл	30,688,731.97	101,822,438.42
210104	Урамшуулал	7,798,326.22	3,016,209.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,163,896.41	39,846,021.50
210201	Тэтгэврийн даатгал	14,455,251.61	29,367,957.04
210202	Тэтгэмжийн даатгал	1,792,026.75	2,293,443.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,717,180.05	1,349,229.15
210204	Ажилгүйдлийн даатгал	371,414.31	2,169,658.06
210205	Эрүүл мэндийн даатгал	3,828,023.69	4,665,734.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,980,582.12	29,226,676.52
210301	Гэрэл, цахилгаан	2,916,700.74	3,101,916.32
210302	Түлш, халаалт	15,313,061.38	21,324,765.00
210303	Цэвэр, бохир ус	5,750,820.00	4,799,995.20
2104	Хангамж, бараа материалын зардал	3,017,600.00	6,604,885.00
210401	Бичиг хэрэг	1,059,000.00	3,312,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,958,600.00	2,312,085.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	979,900.00
2105	Нормативт зардал	41,125,931.00	48,081,932.30
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	102,000.00
210502	Хоол, хүнс	41,125,931.00	47,979,932.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,964,800.00	2,769,100.00
210604	Урсгал засвар	3,964,800.00	2,769,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	215,000.00	229,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	215,000.00	229,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,182,807.48	35,250,061.15
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,178,707.48	32,693,861.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,070,393.88	15,930,295.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,820,176.00	13,407,272.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	46,820,176.00	13,407,272.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,250,217.88	2,523,023.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,250,217.88	2,523,023.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	126,749,911.92	23,926,756.53
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	126,749,911.92	23,926,756.53

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	386,252,516.00	485,307,742.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	36,430,354.00	88,520,942.00
120	Нийтлэг татварын бус орлого	36,430,354.00	88,520,942.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	36,430,354.00	88,520,942.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	36,430,354.00	88,520,942.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	349,822,162.00	396,786,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	320,647,862.00	362,118,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	320,647,862.00	362,118,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,174,300.00	34,668,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,174,300.00	34,668,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	319,409,887.81	454,100,277.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	319,409,887.81	454,100,277.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	270,339,493.93	438,169,981.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	169,550,924.40	307,257,833.52
210101	Үндсэн цалин	131,063,866.21	202,419,185.59
210102	Нэмэгдэл	30,688,731.97	101,822,438.42
210104	Урамшуулал	7,798,326.22	3,016,209.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,163,896.41	39,846,021.50
210201	Тэтгэврийн даатгал	14,444,105.01	29,367,957.04
210202	Тэтгэмжийн даатгал	1,792,026.75	2,507,245.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,717,180.05	1,135,426.65
210204	Ажилгүйдлийн даатгал	382,560.91	2,169,658.06
210205	Эрүүл мэндийн даатгал	3,828,023.69	4,665,734.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,980,582.12	29,226,676.52
210301	Гэрэл, цахилгаан	2,795,917.12	3,101,916.32
210302	Түлш, халаалт	16,384,665.00	21,324,765.00
210303	Цэвэр, бохир ус	4,800,000.00	4,799,995.20
2105	Нормативт зардал	41,174,791.00	47,427,965.00
210502	Хоол, хүнс	41,174,791.00	47,427,965.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,943,500.00	2,919,100.00
210604	Урсгал засвар	2,943,500.00	2,919,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	215,000.00	229,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	215,000.00	229,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,310,800.00	11,263,085.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,663,000.00	7,751,185.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,647,800.00	3,511,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,070,393.88	15,930,295.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,820,176.00	13,407,272.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	46,820,176.00	13,407,272.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,250,217.88	2,523,023.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,250,217.88	2,523,023.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	66,842,628.19	31,207,464.98
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	66,842,628.19	31,207,464.98
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,198,935.44	80,041,563.63
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	80,041,563.63	111,249,028.61

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	370,271,284.46	99,592,480.03	-2,856,847.52	467,006,916.97
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	370,271,284.46	99,592,480.03	-2,856,847.52	467,006,916.97
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-16,416,699.79	-16,416,699.79
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	370,271,284.46	99,592,480.03	148,735,650.83	618,599,415.32
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	370,271,284.46	99,592,480.03	148,735,650.83	618,599,415.32
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	370,271,284.46	99,592,480.03	148,735,650.83	618,599,415.32
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	23,926,756.53	23,926,756.53
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	370,271,284.46	99,592,480.03	172,662,407.36	642,526,171.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	568,422,472.00	447,132,153.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	568,422,472.00	447,132,153.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	555,015,200.00	433,724,881.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	403,969,000.00	307,257,833.52
210101	Үндсэн цалин	265,750,700.00	202,419,185.59
210102	Нэмэгдэл	137,115,100.00	101,822,438.42
210104	Урамшуулал	1,103,200.00	3,016,209.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,561,000.00	39,846,021.50
210201	Тэтгэврийн даатгал	32,224,700.00	29,367,957.04
210202	Тэтгэмжийн даатгал	3,833,600.00	2,507,245.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,917,100.00	1,135,426.65
210204	Ажилгүйдлийн даатгал	1,917,100.00	2,169,658.06
210205	Эрүүл мэндийн даатгал	7,668,500.00	4,665,734.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,668,800.00	29,226,676.52
210301	Гэрэл, цахилгаан	5,544,000.00	3,101,916.32
210302	Түлш, халаалт	21,324,800.00	21,324,765.00
210303	Цэвэр, бохир ус	4,800,000.00	4,799,995.20
2105	Нормативт зардал	53,248,400.00	47,427,965.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	2,919,100.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,919,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,722,600.00	229,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,722,600.00	229,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13845400.00	6817985.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,889,300.00	3,306,085.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,956,100.00	3,511,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13407272.00	13407272.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	13,407,272.00	13,407,272.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,407,272.00	13,407,272.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	568,422,472.00	485,307,742.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	445,232,730.00	362,118,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	445,232,730.00	362,118,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	34,668,800.00	34,668,800.00
132001	Орон нутгийн төсвөөс	34,668,800.00	34,668,800.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	88,520,942.00	88,520,942.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	88,520,942.00	88,520,942.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	80,041,563.63
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	111,249,028.61
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	11.00	11.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	07.00	07.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	03.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 48,126.8 мянган төгрөгийн 4 алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 23,045.1 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг худалдан авсан хөрөнгөөр илэрхийлсэн,
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнг 3,223.2 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн,
- Санхүүгийн үр дүнгийн тайланд бичиг хэргийн зардлыг 1,853.6 мянган төгрөгөөр, бага үнэтэй түргэн элэгдэх, эд зүйлсийн зардлыг 382.5 мянган төгрөгөөр тус тус дутуу илэрхийлсэн,
- 19,546.4 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгохдоо өглөгөөр хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

5.1. Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй

5.2. Албан шаардлага

Илрүүлэлт: Бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтны сургалтын төлбөрт 290.000 төгрөг, архивын ажилтны сургалтын төлбөрт 80.000 төгрөгийг төлсөн боловч сургалтын хөтөлбөр, удирдамж байхгүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 23,045.1 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг худалдан авсан хөрөнгөөр илэрхийлсэн	1	23,045.1			1	23,045.1	1	23,045.1				
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөөнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнг 3,223.2 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн	1	3,223.2			1	3,223.2	1	3,223.2				
Санхүүгийн үр дүнгийн тайланд бичиг хэргийн зардлыг 1,853.6 мянган төгрөгөөр, бага үнэтэй түргэн элэгдэх, эд зүйлсийн зардлыг 382.5 мянган төгрөгөөр тус тус дутуу илэрхийлсэн	1	2,312.1			1	2,312.1	1	2,312.1				
19,546.4 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгохдоо өглөгөөр хүлээн зөвшөөрч тайлагнасан	1	19,546.4			1	19,546.4	1	19,546.4				
ДҮН	4	48,126.8			4	48,126.8	4	48,126.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Үүнээс			
									Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтны сургалтын төлбөрт 290.000 төгрөг, архивын ажилтны сургалтын төлбөрт 80.000 төгрөгийг төлсөн боловч сургалтын хөтөлбөр, удирдамж байхгүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй байна.	1	370.0			1	370.0						

Дүн	1	370.0			1	370.0				
-----	---	-------	--	--	---	-------	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1-12 дугаар сард гэрээ хэлцэл байгуулах, захиргааны шийдвэр гаргах, хөрөнгө зарцуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хөтөлж шилэн дансанд байршуулаагүй байна.	1	0					1	0
Дүн	1	0					1	0